



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/100.

Номгон

Нэгдсэн үндэсний байгууллагатай хамтран
Бууцагаан сумд нарны цахилгаан халаагууртай
контейнерт суурилуулсан хөргөлтийн систем
хийх ажлыг хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны төсөв батлах тухай 9/57 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт, аймгийн 2026 онд хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал"-ын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сантай хамтран Бууцагаан сумд нарны цахилгаан халаагууртай контейнерт суурилуулсан хөргөлтийн систем суурилуулах төслийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах гэрээний ажлыг хүлээлцэж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Дагвадорж

Бууцагаан сумын Засаг дарга

Гишүүд:

Д.Баатар

Бууцагаан сумын Мал эмнэлгийн тасгийн
мэргэжилтэн

С.Батзориг

Бууцагаан сумын 2 дугаар багийн Засаг дарга

Б.Ерөөлт-Очир

Бууцагаан сумын 3 дугаар багийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Баасанбат


Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сантай хамтран Бууцагаан сумд нарны цахилгаан халаагууртай контейнерт суурилуулсан хөргөлтийн систем суурилуулах гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлыг нягтлан шалгаж хүлээн авах, ажлын гүйцэтгэл, явцын тайлан, дүгнэлт болон холбогдох баримт бичгийг хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Дагвадорж)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ



626010247

D:\2026\1.Zakhiramj\Zghiramj 01.docx

...در خصوص نام رسمی شرکت فوق الذکر میوه و سبزی در فهرست شرکتها (ف.ن.س.ک) -
فوق مستثنی است ..

